“Эртний монгол төөнийн бичиг” зохиол дахь толгойн төөнийн бэлчрийн байршил, төөнөх заалтыг харьцуулан судалсан үр дүн

Б.Алтантулга[1], З.Болортулга[2], Ш.Болд[1], С.Доржбат[1]

[1]АШУҮИС, МАУОУС, Монгол Анагаах Ухаан Судлалын тэнхим
[2]АШУҮИС, МАУОУС,Уламжлалт эмчилгээний тэнхим
Цахим шуудан :Tulga_leah@yahoo.com, Утас: 99993515

Түлхүүр үг:

Эртний монгол
Төөнийн бичиг
Төөнө
Засал
Бэлчир

Товч утга:

Үндэслэл: Монгол анагаах ухааны төөнөх засал хоёр мянган жилийн өмнөх Сяньби аймаг үндэстний үүсэл гаралтай нягт холбоотой. Эртний Вэй улсын түүх сударт, “Нүүдэлчин Сяньбичууд өвчтэй хүмүүсийг ул өвсөн галаар төөнөх, чулууг халааж төөнөх зэргээр эмчлэх эртний арга барилаа хадгалсаар ирсэн гэж тэмдэглэсэн байдаг. Хэдийгээр уламжлалт анагаах ухааны төөнө засалтай холбоотой түүх, хөгжлийн талаар дурдсан ололттой талууд байгаа хэдий ч төөнийн эртний ном судрыг Монгол үндэстэн хэдий үеэс эхлэн өөрийн хэлээр бичиж орчуулсан, орчуулгын зохиол болон үндсэн эх сурвалжийн харьцуулсан, дүн шинжлэл хийсэн судалгаа хомс байгаа нь бидний судалгааны үндэслэл болж байна. **Зорилго: “**Эртний Монгол төөнийн бичиг” сурвалж зохиол дахь монгол төөнийн толгойн хэсэгт байрлах бэлчрийн байршил нэршил, төөнөх заалтыг харьцуулан тодруулах. **Арга, аргачлал:** Бид судалгаандаа Дуван Гомбожав “Эртний Монгол төөнийн бичиг” нэрээр хуучин монгол бичгээр бичсэн гар бичмэл бүхий 1992 онд хэвлүүлсэн нийт 27 хуудастай эх зохиолыг “Анагаах ухааны дөрвөн үндэс”-н Хойд үндэсийн шинжлэл заслын 21-р Төөнөх засал бүлэг, Хятад анагаах ухааны Зүү төөнө заслын холбоо “Зүү төөнө заслын сүвийн байршил “ эх зохиолуудыг хэрэглэгдэхүүн болгон эх бичиг сурвалж судлалын харьцуулах аргаар харьцуулан, магадлан жагсаах аргаар төрөлжүүлэн онцлогийг тодруулж, өвөрмөц үг хэллэгийг задлан шинжлэн тайлбарлаж, нэгтгэн дүгнэх аргыг ашиглан төөнийн бэлчир орон, байршил, төөнөх заалтыг тодруулав. **Үр дүн:** Бидний судалгаанд “Эртний монгол төөний бичиг” зохиолд бичигдсэн толгойн төөнийн бэлчир нь 22 биш 13 байв. “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолын Хойд үндэст тэмдэглэгдсэн 3 бэлчир орон ойролцоо байршилтай, Зүү төөнө заслын сүвийн байршилтай харьцуулахад 5 бэлчир орноос 4 нь сүвийн байршил төстэй байгаа хэдий ч 1 сүвийн байршил зөрүүтэй, нэршлийн хувьд ялгаатай болохыг тодруулав. Бусад үлдсэн 10 төөнөх бэлчир нь “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолын Хойд үндэс-т тэмдэглэгдээгүй, Хятад анагаах ухааны зүү төөнө заслын сүвийн байршилтай харьцуулахад ижил төстэй байршил бүхий сүв олдсонгүй. Мөн тус 13 бэлчир орныг илэрхийлсэн байршлын үг хэллэг нь төвөд болон хятад үг хэллэг огтхон ч хэрэглээгүй ба монгол үг хэллэгээр бичигдсэн байгаа нь Монгол хүний бичсэн төөнийн эх сурвалж болохыг нотлох боломжтой байгаа юм. Толгойд байрлах 13 бэлчир орны 2 бэлчир орон нь АУДҮ-зохиолын Хойд үндэст бичигдсэн төөнөх заалттай ойролцоо байв. Мөн Зүү төөнө заслын сүвээс 4 сүвийн байршил ижил төстэй ч эмчилгээний заалтын хувьд нэг хоёр заалт ижил боловч бусад эмчилгээний заалтууд ялгаатай байлаа. Түүнчлэн 11 бэлчир орны эмчилгээний заалт нь Анагаах Ухааны Дөрвөн Үндэс зохиолд огт дурдагдаагүй бөгөөд 9 бэлчир орны эмчилгээний заалт нь зүү төөнө заслын сүвийн эмчилгээний заалтаас ялгаатай болохыг тогтоолоо. **Дүгнэлт:** 1. “Эртний Монгол төөнийн бичиг” зохиолд бичигдсэн толгойн хэсэгт байрлах 11 бэлчир нь байршил болон нэршлийн хувьд ялгаатай болохыг тодруулав. 2. Тухайн зохиолд бичигдсэн 13 бэлчир орны 11 нь Анагаах Ухааны Дөрвөн Үндэс зохиолын Хойд үндэст огт дурдагдаагүй бөгөөд 13 бэлчир орны төөнөх заалт нь зүү төөнө заслын сүвийн эмчилгээний заалттай ялгаатай байв. 3. Толгойн хэсгийн төөнийн бэлчир орны нэршил, байршил, эмчилгээний заалт нь төвд болон хятад уг гаралтай үг хэллэгээр бичигдээгүй, монгол хэлний өвөрмөц үг хэллэгээр элбэг байгаа нь монголчуудын бичсэн зохиол болохыг нотлож байна.

Үндэслэл: Монгол анагаах ухааны төөнөх засал хоёр мянган жилийн өмнөх Сяньби аймаг үндэстний үүсэл гаралтай нягт холбоотой.[1] Эртний Вэй улсын түүх сударт, "Нүүдэлчин Сяньбичууд өвчтэй хүмүүсийг ул өвсөн галаар төөнөх, чулууг халааж төөнөх зэргээр эмчлэх эртний арга барилаа хадгалсаар ирсэн гэж тэмдэглэсэн байдаг[2.] XVI зууны үед "Анагаах ухааны язгуурын үндэс"-ийг монголчлон орчуулах үед, "Хоржи мэза" гэдэг төөнөх заслыг "Монголын төөнө" гэж орчуулсан байна. "Монголын төөнө" гэдэг нь, "Язгуур үндэс"-ийн тайлбар зохиолд, "Зоргодосыг тостой хольж халаагаад эсгийд ороож төөнөх"-г хэлнэ гэж тайлбарлажээ[3,4]. Хэдийгээр уламжлалт анагаах ухааны төөнө засалтай холбоотой түүх, хөгжлийн талаар дурдсан ололттой тал байгаа хэдий ч төөнийн эртний ном судрыг Монгол үндэстэн хэдий үеэс эхлэн өөрийн хэлээр бичиж орчуулсан, орчуулгын зохиол болон үндсэн эх сурвалжийн судалгаа хомс байна.

Зорилго: "Эртний Монгол төөнийн бичиг" хэмээх сурвалж зохиол дахь монгол төөнийн толгойн хэсэгт байрлах бэлчрийн байршил нэршил, төөнөх заалтыг харьцуулан тодруулахад оршино.

Зорилт:

1. "Эртний монгол төөнийн бичиг" зохиолд бичгдсэн толгойн төөнийн бэлчир орны байршил, нэршлийг харьцуулан тодруулах
2. Толгойн хэсгийн төөнийн бэлчрийн төөнөх эмчилгээний заалтыг харьцуулан судлах

Арга, аргачлал: Бид судалгаандаа Дуван Гомбожав "Эртний Монгол төөнийн бичиг"[5] нэрээр хуучин монгол бичгээр гараар бичсэн 1992 онд хэвлүүлсэн нийт 27 хуудастай эх зохиолыг "Анагаах ухааны дөрвөн үндэс"[6] Өвөр монголын үндэсний хэвлэлийн хороо 1996 он Хойд үндэс-ийн шинжлэл заслын 21-р Төөнөх засал бүлэг, Н.Төмөрбаатар "Зүү төөнө заслын суваг сүвийн хэмжил зүй"[7] Улаанбаатар хот 2021 он, Хятад анагаах ухааны Зүү төөнө заслын холбоо "Зүү төөнө заслын сүвийн байршил"[8]- ном, зохиолуудыг эх хэрэглэгдэхүүн болгон эх бичиг сурвалж судлалын харьцуулах аргаар харьцуулан[9], магадлан жагсаах аргаар төрөлжүүлж, онцлогийг тодруулан, өвөрмөц үг хэллэгийг задлан шинжлэн тайлбарлаж, нэгтгэн дүгнэх [10] аргыг ашиглан төөнийн бэлчир орон, байршил, төөнөх заалтыг тодрууллаа. АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022 оны 04 сарын 29-ний хурлын №2022/3-04 тоот хурлаар зоихих зөвшөөрөл авч хийж гүйцэтгэв.

Үр дүн: Бидний судалгаанд "Эртний монгол төөний бичиг" зохиолд бичигдсэн толгойн төөнийн бэлчир нь 22 биш 13 бэлчрийг болох тогтоов. "Анагаах ухааны дөрвөн үндэс" зохиолын Хойд үндэс-т тэмдэглэгдсэн 3 бэлчир нь ойролцоо байршилтай байна. Түүнчлэн Зүү төөнө заслын сүвийн байршилтай харьцуулахад 5 бэлчир нь ойролцоо байгаа хэдий ч 4 сүвийн байршил нь тохирч, 1 сүвийн байршил зөрүүтэй, нэршлийн хувьд ялгаатай болохыг тодруулав. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Эртний монгол төөнийн бичиг зохиолд бичигдсэн толгойн хэсгийн төстэй бэлчир орны байршлыг харьцуулсан үр дүн

№	Эртний монгол төөнийн бичиг	Тайлбар	АУ-ны дөрвөн үндэс	Зүүний сүвийн нэршил
1	Оройн баруун зүүн хөндлөнгөөр залгамжлан хэмжиж төөнөх	Хоёр чихний дээд үзүүрийг холбосон шугам толгойн хөндлөн шугамтай огтололцлыг хэлнэ	Оройн бэлчир	Baihui -Зуу нийлэх * Толгойн гол шугамаар үсний захаас 5 цунд 2 чихний отгийг холбосон шулууны огтлолцох цэгт
2	Оройгоос нэжгээд ямхын[5] зуур төөнөх	Оройн бэлчрээс 4 тийш нэг нэг ямх зайд оршино.	Оройн хурмалаас өмнө 1 ямх элэгний бэлчир, арагш нэг ямх бөөрний бэлчир, зүүн тийш нэг ямх зүрхний бэлчир, баруун тийш нэг ямх уушгины бэлчир хэмээжээ.	Si shen cong* EX-HN1 Baihui сүвийн баруун зүүн өмнө хойно талд 1 цунд
3	Хоёр хөмсгийн зуур төөнөх	Хоёр хөмсөгний дотор үзүүрийг холбосны дунд	-	印堂穴Ying tang * Хөмсөгний хоёр эхлэлийг холбосон шулууны голд
4	Хоёр чихний үзүүрийн судсыг төөнөх	Чихний дээд оройн үзүүрторших судас дээр	Чихний оройн үзүүрт орших судас дээр	角孙穴位Jiao sun * Чихний дээд торгон үзүүрт
5	Чихний үзүүрээс дээш нэгэн ямх хэмжиж зүүн баруун этгээд 2 орон бэлчир	Чихний оройгоос дээш 1 ямх зүүн баруун 2 орон бэлчир	-	率谷穴* чихний оройгоос 1,5 цунд нэг сүв

Тайлбар: *[12]Baihui GV20* - Арын гол Dumai сувгийн 20 дугаар сүв*
Si shen cong EX-HN1 - Ой ухаан цэцэн цэлмэг- Толгойн сувгийн гаднах нэгдүгээр сүв*
Ying tang Ex-HN3 - Толгойн сувгийн гаднах гуравдугаар сүв*
Jiao sun TE-20 - Биеийн гурван халуун гарын шао янгийн сувгийн 20 дугаар сүв*
Shuai gu GB8 - хөлийн цөсний сувгийн 8 дугаар сүв*

Тус зохиолын толгойн хэсэгт байрлах дараах 10 төөнөх бэлчир нь “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолын Хойд үндэс-т тэмдэглэгдээгүй бөгөөд Хятад Анагаах Ухааны зүү төөнө заслын сүвийн байршилтай харьцуулахад ижил төстэй байршил бүхий сүвийг олсонгүй. Мөн тус 10 бэлчир орныг илэрхийлсэн байршлын үг хэллэг нь төвөд болон хятад үг хэллэг огтхон ч хэрэглээгүй монгол үг хэллэгээр бичигдсэн байгаа нь монгол төөнийн эх сурвалж болохыг нотлох боломжтой гэж үзээд үгийн тайлбаруудыг дэлгэрүүлэн тодруулав. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Толгойн хэсгийн ялгаатай бэлчир орны нэршлийн тайлбар, байршлыг харьцуулсан үр дүн

№	Эртний монгол төөнийн бичиг	Байршлын үгийн тайлбар	Зүүний сүвийн нэршил
1	Гэзгийн далай	Албаны хар хүн толгойн ар дагзны хэсэгт үс үлдээхийг гэзэг гэдэг.	-
2	Гэзгийн ясан дээр	Дагзны товгор ясан дээр	Naokong GB19* - Дагзны ясны төвгөрийн дээд ирмэгийн түвшинд Nahou сүвээс гадагш 2,25 цунд байна
3	Нүдэнд зовхисоос гурван хуруу хэмжиж, үсний завсар түвшинд	-	Toulinqi GB15 -Хүүхэн хараатай нэг түвшинд, үсний урд захаас дотогш 0,5 цунд Shenting GV14, Touwei ST8 хоёрыг холбосон шулууны голд
4	Эрүүний яснаас чихэн тус ямхад	асун туулан- насан тоогоор төөнөх	-
5	Нүдний дундаас шударга татаж, үсний завсарт нэжгээд	Гадар дотор зовхи хооронды гол цэгээс дээш үсний завсарт /магнай үсний үзүүрт хоёр тийш нэг нэг ямх 3 орон бэлчир /	Shenting GV24* - Нүүр, толгойн гол шугамаар, үсний урд захаас эгц дээшээ 0,5 цунд байна
6	Оройгоос хойш дөрвөн хуруу хэмжиж, гэзгийн зажуур ясан дээр	Гэзэг нь дагзний хэсэгт байрладаг Зажуур яс- чамархайн яс	-
7	Хоёр нүдний зуур	Хоёр нүдний хүүхэн харааг холбосны гол дунд	-
8	Хамрын ясны чигт үзүүр дээр	Хамрын үзүүрт	-
9	Чихний үзүүрээс дээш нэгэн ямх хэмжиж зүүн баруун этгээд 2 орон бэлчир	Чихний оройгоос дээш 1 ямх зүүн баруун талд 2 орон бэлчир	率谷穴Shuaigu GB8* - Чамархайн дээр, чихний омог, үсний захаас эгц дээшээ 1,5 цун Jiaosun TE20 сүвийн дээд талд буюу чихний омог зулайн төвгөр хоёрыг холбосон шулууны голд байрлана

Тайлбар: *Naohu GV17* - Арын гол Dumai сувгийн 17-дугаар сүв*
Naokong GB19 - Тархины хөндий - Хөлийн цөсний сувгийн 19-дүгээр сүв*
Shenting GV24 - Сүнс оюун санаа - Арын гол Dumai сувгийн 24-дүгээр сүв*
Toulinqi GB15 - Толгой эмнэх нулимс гоожих - Хөлийн цөсний сувгийн 15-дугаар сүв*
Shuaigu GB8 - 足少阳胆经 - Хөлийн цөсний сувгийн 8-дугаар сүв*
Nahou GV17 - Толгойн гол шугамаар дагзны төвгөрийн дээд хонхорт буюу*
Fengfu GV16 сүвээс эгц дээш 1,5 цунд орших тул зөрүүтэй байна.

“Эртний Монгол төөнийн бичиг” зохиолд бичигдсэн толгойд байрлах 13 бэлчрийн 2 бэлчир нь АУДҮ-зохиолын Хойд үндэст бичигдсэн эмчилгээний заалт ойролцоо байв. Мөн зүү төөнө заслын сүвээс 4 сүвийн байршил ижил төстэй ч эмчилгээний заалтын хувьд тодийлөн ойролцоо бичигдсэн байдал цөөн байсан боловч бусад эмчилгээний заалтууд ялгаатай болохыг тогтоов. Түүнчлэн тус зохиолд бичигдсэн 11 бэлчрийн эмчилгээний заалт нь “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” зохиолд огт дурдагдаагүй, зүү төөнө заслын сүвийн эмчилгээний заалтаас 9 бэлчрийн эмчилгээний заалт нь ялгаатай болохыг тодруулав. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Толгойн хэсгийн ижил байршилд байрлах бэлчир орны эмчилгээний заалтыг харьцуулсан үр дүн

Зохиолууд	Төстэй заалт	Ялгаатай заалт
Нэгдүгээр бэлчир - Оройн төвөнх бэлчир		
ЭМТБ	Толгойн бүх өвчин, тэргүүний хий, үхэтхийж манаран унах	Галзуу найралчлан- солио
АУДҮ	Хийгээр толгой өвдөх, муужрах, хэлгийрэх, болох үед төөнөнө	Хараа муудах, хамраас цус гарах, мартамхай
Зүүний сүв	Толгой өвдөх, унадаг өвчин, ой муудах, мартамхай болох, толгой эргэх,	Хамар битүүрэх, цагаан мах урвах, умай урвах, нүд бүрэлзэх, зүрх дэлсэх сэтгэцийн эмгэгүүд,
Хоёрдугаар бэлчир- Оройгоос нэжгээд ямхын[5] зуур бэлчир		
ЭМТБ	Галзуу найралчлан[4] үхэтхийн согтуурахуй	Толгой эргэх ба хүзүү хөших галзуу найралчлан[4] үхэтхийн сугадрах хийгээд бүгд өвчинд тус болох ам хазайх Хий халууны зүйл ба хамаг хийн хавдар өвчинд тус болох.
АУДҮ	Солиорох, манарах, муужирч унах үед төөнөнө.	Оройн өмнөх (Элэгний бэлчир) Өрцнөөс болсон зовиур шаналгаа Оройн арын Бөөрний бэлчир- Бөөрний өвчнүүд, хөл шимширч өвдөх, цайвар хаван, Оройн баруун- Уушигны бэлчир- Уушгины хатгалга, нүүр хавдах, солиорох, манарах Оройн зүүн Зүрхний бэлчир Уурлаж уцаарлах, жихүүдэс хүрэх, муужирч унах
Зүүний сүвийн заалт	Унадаг өвчин	Си жи сун Sishen cong- Тархинд цус харвах, тал биеийн саа, толгой өвдөх, нүд эрээлжлэх, сэтгэц мэдрэлийн эмгэг, тархины цусан хангамж муудах
Аравдугаар бэлчир - Хоёр хөмсгийн зуур		
ЭМТБ	Нүдний яс (ухархай) өвдөхөд тус болох.	Махан хээвэр[8] нүдэн дүүрэх ба нүдний яс (ухархай) өвдөхөд тус болох. Махан ширхэг /мах ургах/,
Зүүний сүвийн заалт	Нүдний өвчин	Интан -印堂穴- Таталт, толгой өвдөх, хамар битүүрэх, нүдний өвчин, толгой эргэх, нойр хулжих
Арванхоёрдугаар - Хоёр чихний үзүүрийн судсанд төөнөх		
ЭМТБ	Чихний яс өвдөх хийгээд чихний хамаг өвчнөө	Судсыг төөнөвөөс чихэн дүлий болох ба чихний яс өвдөх хийгээд чихний хамаг өвчнөө тус болох. Уруул дорогш унжсан ба уруулын өвчнөө тус болох.
Зүү сүвийн заалт	Чих хавдах, улайх	角孙穴- TE-20 Жяао сун Чих хавдах, улайх, толгой өвдөх, нүд улайх хавдах, хүзүү хөших хараа муудах буйл хавдах
Зүү сүв заалт	4 бэлчир	9 бэлчир
АУДҮндэс	2 бэлчир	11 бэлчир

Хэлцэмж: Монголын уламжлалт засал болох “Монголын төөнө”-д “чулууг тосонд чанаад жигнэх” эртний Сяньби аймгийнхны халуун чулуун төөнө, зоргодос (гоньд), жоншыг тостой холиод халааж тавих, эсгий болон шар тос ашиглан төөнөх зэрэг аргууд багтдаг.[11] Эдгээр төөнөх заслын аргууд нь хүйтэн чанартай өвчнийг анагаах халуун засал бөгөөд монголчуудын ахуй амьдрал, нүүдлийн хэв маяг, дийлэнхдээ хүйтэн уур амьсгал зонхилдог, монгол орны байгалийн нөхцөлд тохирсон өвөрмөц онцлогтой засал юм.[12] Иймд олон зуун жилийн турш түүхэн улбаагаар өвлөгдөн ирсэн төөнө заслын эмчилгээний аргыг орчин үеийн эмчилгээний хэлбэрт оруулж боловсронгуй болгох, цаашлаад Соёлын биет бус өвд бүртгүүлэх зэрэг бодлогын хүрээнд хөгжүүлэх шаардлага байгаа юм. Энэ үүднээс монгол төөнө заслын эх сурвалж зохиолуудын онцлогыг тодруулан төөнөх бэлчир орон, төөнөх заалт, эсрэг заалтыг тодорхой цэгцтэй судлан нотолгоожуулан эмнэлзүйн хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж үзэж байна.

Судлаач Хөгжил Буянт[13] нарын 2015 он “Эртний монгол төөнийн бичиг” дэх хэл хэллэгийн онцлогоос түүний үнэ өртөгийг үнэлэх нь судалгаандаа Монголчууд уйгур, хятад, монгол зэрэг олон хэлний үсэг бичгийг хэрэглэж байсан тул анагаах ухааны ном бичиг ч эдгээр хэлээр ихээхэн бичигдэж байсан, гэвч анагаах ухааны тулгар бичгээс монгол оронд үлдэж хоцорсон нэг зүйл бол “Монгол төөнө”-ийн бичгийн эх сурвалж нь хятад үсгээр бичигдсэн “Идээн ундааны жинхэнэ товч”-оос нэн их судалгааны үнэ цэнтэй болно хэмээжээ. Мөн Б.Эрдэнэбулга[14] нарын 2018 он “Эртний монгол төөнө бичгийг бусад ижил төрлийн зохиолуудтай харьцуулсан судалгаандаа толгойн 13 бэлчир судлагдснаас Хөх биндэрьяа, Зарлигийн эрхэст

харанхуйг арилгагч зул зохиолуудтай харьцуулахад ижил төстэй 1, байршил ижил ч эмчилгээний заалт ялгаатай 3, огт бичигдээгүй 9 бэлчир байна гэсэн бидний судалгаагаар тодруулсан 10 бэлчир бичигдээгүй, 3 бэлчир ойролцоо, 11 бэлчрийн эмчилгээний заалт ялгаатай байгаа нь тохирч байгаа ч үлдсэн 1-2 бэлчир оронг орхидуулсан байж болзошгүй байна. Цаашид тус зохиолын "Зуун далан долоон эхт" төөнийн бэлчрийг тодруулах нь Монгол төөнийн өвөрмөц талаас судалж болох гүн гүнзгий ач холбогдолтой болно хэмээн үзэж байна.

Дүгнэлт:

1. "Эртний Монгол төөнийн бичиг" зохиолд тэмдэглэгдсэн толгойн хэсгийн төөнийн 11 бэлчир орны нэршил, байршил, эмчилгээний заалт нь төвд болон хятад уг гаралтай үг хэллэгээр бичигдээгүй, монгол хэлний өвөрмөц үг хэллэгээр монголчуудын бичсэн зохиол бөгөөд төөнийн бэлчир нь бусад эх сурвалжуудаас байршил болон нэршлийн хувьд ялгаатай болохыг тодруулав.
2. Тухайн зохиолд бичигдсэн 13 бэлчир орны 11 нь Анагаах Ухааны Дөрвөн Үндэс зохиолын Хойд үндэст огт дурдагдаагүй бөгөөд 13 бэлчир орны 4 бэлчир нь нэг хоёр эмчилгээний заалтаар нь зүү төөнө заслын сүвийн эмчилгээний заалттай төстэй ч бусад эмчилгээний заалтаар ялгаатай байв.

Талархал: Судалгааг хийхэд тусалж дэмжсэн МАУОУСургууль болон АШУҮИСургуулийн нийт доктор, профессор, эрдэмтэн судлаач багш нарт гүнээ талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Ш.Болд Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2005, х 17*
2. *Намтай Б. "XIII-XIV зууны Монголын анагаах ухааны түүхэн хөгжил" Анагаах ухааны докторын зэрэг горилон туурвисан нэг сэдэвт зохиол. УБ, 2007, х 90*
3. *Ш. Болд Монголын анагаах ухааны түүх. УБ, 2006. х.26*
4. *Ш. Болд Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х 180-182*
5. *Дуван Гомбожав "Эртний монгол төөнийн бичиг" хуучин монгол бичиг. 1992 х.1-29*
6. *"Анагаах ухааны дөрвөн үндэс" Хойд үндэс-ийн шинжлэл заслын 21-р Төөнөх засал бүлэг 1996 он Өвөр монголын хэвлэлийн хороо*
7. *Н.Төмөрбаатар "Зүү төөнө заслын суваг сүвийн хэмжил зүй"7 2021он УБ хот*
8. *ХАУ-ны зүүний эмч нарын гарын авлага "Зүү төөнийн сүвийн байршил " 2010 он*
9. *И.К. Ковальченко "Метод исторического исследавонная 2003 он х186-220*
10. *Трактаты об иглоукалывании и прижигании. (Научный руководитель перевода и ответственный редактор П.Ц.Биткеев). Издательство "Наука", Москва, 1987*
11. *Жигмэд Монгол анагаах ухааны түүх ӨМӨЗО 2002он х39-57*
12. *Charles C. Ragin. The Comparative Method: Moving beyond qualitative and quantitative strategies. University of California Press, 1987. p. 12-16*
13. *Хөгжилбат. Буянт "Эртний монгол төөнийн бичиг" дэх хэл хэллэгийн онцлогоос түүний үнэ өртөгийг үнэлэх нь 2015.10. х 92-96*
14. *Б.Эрдэнэбулга "Эртний монгол төөнө бичгийг бусад ижил төрлийн зохиолуудтай харьцуулсан судалгаа 2018он х. 35-64*

The results of a study comparing the therapeutic indications of head moxibustion points in “Ancient Mongolian Moxibustion books” literature

Altantulga B[1], Bolortulga Z,[2] Bold Sh[1], Dorjbat S[1]

[1]Department of Mongolian Medicine, ISMM, MNUMS
[2]Department of Traditional Therapy, ISMM, MNUMS
E-mail: Tulga_leah@yahoo.com, Tel: +976-99993515

Background: The moxibustion treatment of Mongolian medicine is closely related to the origins of Xianbi province two thousand years ago. In the ancient history of Wei, it is recorded that “the nomadic Xianbei have preserved the ancient method of treating the sick by burning them with grass and burning them with stones.” Although there are achievements related to the history and development of traditional medicine moxibustion treatment, there is a lack of research on the translation texts and primary sources of the moxibustion treatment ancient books written and translated in their own language since the time when the Mongolian nation was born.
Aim: The aim is to compare the names of the moxibustion point’s location and moxibustion indicated by Mongolian moxibustion in the ancient book “Ancient Mongolian of moxibustion treatment textbook”.
Materials and Methods: In our research, we compared the 27-page original textbook written by DuvanGombojav in written in ancient Mongolian language writing in 1992 under the name “Ancient Mongolian moxibustionTextbook” with the 21st Chapter moxibustion of the Analysis of the fourth part called the subsequent tantra from the secret quintessential instructions on the eight branches of the ambrosia essence tantra. It was studied using enumeration methods, comparative analysis, summarizing methods, and probabilistic list methods were used to compare and clarify the moxibustion points of the indicated Mongolian moxibustion.
Results: There are 13 moxibustion points located in the head in the “Ancient Mongolian moxibustionTextbook”, and the 4 moxibustion points located in the “21st Chapter moxibustion of the Analysis of the fourth part called the subsequent tantra from the secret quintessential instructions on the eight branches of the ambrosia essence tantra” is located near the country text are located close to the head, 10 moxibustion points located have different positions, and the indications for treatment of conjunctivitis are different.
Conclusion:

1. In the “Ancient Mongolian of moxibustion treatment textbook” the text on the moxibustion points and treatment indications they not written in words of Tibetan or Chinese origin, but the fact that it is full of words unique to the Mongolian language proves that it is a text written by Mongolians.
2. The text clarifies that some of the confluences on the head listed in the 21st Chapter moxibustion of the Analysis of the fourth part called the subsequent tantra from the secret quintessential instructions on the eight branches of the ambrosia essence tantra” are different in terms of moxibustion points location and treatment indications.

Keywords: Moxibustion point, Moxibustion, Moxibustion treatment